

Growth

Success

Expansion

InvesCore
САНХҮҮГИЙН ГРУПП

“Инвескор ББСБ” ХК

2022 он

Үйл ажиллагааны тайлан /нэгтгэсэн/

7709 - 0077

info@invescore.mn

www.invescore.mn

1. Гол амжилтууд	2. Компанийн бүтэц	3. Зээлийн үйл ажиллагаа	4. Борлуулалтын суваг	5. Олон улсын зах зээл	6. Покет - Дижитал зээл
7. Платинум Кредит карт	8. Нийгмийн хариуцлага	9. Компанийн засаглал	10. Санхүүгийн үр дүн	11. Зохистой харьцааны үзүүлэлтүүд	12. Хувьцааны ханш

Агуулга

1. Гол амжилтууд	03-05
2. Компанийн бүтэц	06
3. Зээлийн үйл ажиллагаа	07
4. Борлуулалтын суваг	08
5. Олон Улсын зах зээл	09
6. Покет-Дижитал зээл	10
7. Платинум Кредит карт	11
8. Нийгмийн хариуцлага	12-13
9. Компанийн засаглал	14-16
10. Санхүүгийн үр дүн	17-18
11. Зохистой харьцааны үзүүлэлтүүд	19
12. Хувьцааны ханш	20

Гол амжилтууд



Олон улсын “MicroFinanza Rating” SRL байгууллагаас авсан үнэлгээгээ **“A”** болгон ахиулж, Монгол Улсын санхүүгийн байгууллагууд дундаа хамгийн өндөр үнэлгээ авлаа.



Өсөлт • Амжилт • Тэлэлт

Хөрөнгийн бирж дээр 5.3 хувь буюу 4 сая ширхэг нэмэлт хувьцаагаа санал болгож **16.7 тэрбум** төгрөгийг 100 хувийн амжилттайгаар татан төвлөрүүллээ.



Чанарын удирдлага (**ISO9001**) болон мэдээллийн аюулгүй байдлын (**ISO27001**) стандартыг нэвтрүүллээ.



Нэгж хувьцаанд 25 төгрөг буюу нийт **1.8 тэрбум** төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигч нартаа тараалаа.

Гол амжилтууд



Нидерланд улсын Краудфандинг платформ болох “Hands-on B.V.” компаниас **2.5 сая ам.доллар** татах хэлэлцээр хийсэн бөгөөд эхний 7 транч амжилттай болж, 8 дахь транч хүлээгдэж байна.



50 тэрбум төгрөгийн “Инвескор бонд” нээлттэй бондын хөтөлбөрийг батлуулж, эхний 2 транчийг амжилттай хэрэгжүүлэн **20 тэрбум** төгрөгийг татан төвлөрүүлээ.



Инвескор санхүүгийн байгууллага нь Катар Улсад зохион байгуулагдсан Хөлбөмбөгийн ДАШТ-ийн шууд дамжуулалтын **Ерөнхий ивээн тэтгэгчээр** ажиллалаа.



“Инвескор ББСБ” ХК нь Голомт банктай хамтарч, үнэнч харилцагчдадаа зориулан Инвескор платинум **кредит картыг** хэрэглээнд нэвтрүүллээ.

НЭМЭЛТ ХУВЬЦАА - FPO



Инвескор ББСБ ХК нь 4,016,363 ширхэг нэмэлт хувьцаагаа тус бүр нь 4,155 төгрөгийн үнээр олон нийтэд санал болгож 16.7 тэрбум төгрөгийг татан төвлөрүүллээ. Ингэснээр компанийн олон нийтийн эзэмшлийн хувь 19.51% болж нэмэгдлээ.



НЭЭЛТТЭЙ БОНДЫН ХӨТӨЛБӨР

Инвескор ББСБ ХК нь 50 тэрбум төгрөгийн дүнтэй, 100% эргэн төлөгдөх баталгаатай, "ИНВЕСКОР БОНД" нээлттэй бондын хөтөлбөрийн эхний 2 транчийг амжилттай хэрэгжүүлж 20 тэрбум төгрөгийг 100%-ийн амжилттай татан төвлөрүүллээ.

Компанийн бүтэц



“Инвескор ББСБ” ХК нь бичил санхүүгийн зах зээлд дэвшилтэт технологи, шинэлэг шуурхай үйлчилгээг нэвтрүүлж, харилцагчдынхаа санхүүгийн “хариуцлагатай дэмжигч” байх зорилготойгоор 2016 онд байгуулагдсан.

Охин компанийн мэдээлэл

70%



“Инвескор Си Эй” МФК

Киргиз улс дахь бичил санхүүгийн компани.

2020

100%



“Покет КГ” ХХК

Киргиз улсын зах зээлд Покет платформыг нэвтрүүлж байна.

2020

100%



“Инвескор Хэтэвч ББСБ” ХХК

Покет платформд суурилсан цахим зээлийн төв, дижитал хэтэвч болон бусад үйлчилгээнүүд.

2019

75%



“Инвескор Актив” ТЗК ХХК

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан тусгай зориулалттай компани.

2020

100%




“Инвескор КЗ” ХХК

Казахстан улс дахь охин компани.

2022

Зээлийн үйл ажиллагаа

Зээлийн багц, харилцагчийн тоо



Зээлийн багц өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 63 хувиар өсч 283 тэрбум төгрөг, харилцагчийн тоо 128 хувиар өсч 182 мянгад тус тус хүрсэн байна.

Зээлийн багц (бүтээгдэхүүнээр %)



Зээлийн багцын чанар

2020




2021



2022.Q3



2022.Q4



■ Хугацаа хэтэрсэн ■ Чанаргүй

Агуулга

1. Гол амжилтууд

2. Компанийн бүтэц

3. Зээлийн үйл ажиллагаа

4. Борлуулалтын суваг

5. Олон улсын зах зээл

6. Покет - Дижитал зээл

7. Платинум Кредит карт

8. Нийгмийн хариуцлага


9. Компанийн засаглал

10. Санхүүгийн үр дүн

11. Зохистой харьцааны үзүүлэлтүүд

12. Хувьцааны ханш

Борлуулалтын суваг



17 салбар

Инвескор ББСБ ХК нь Монгол Улсад нийт 17 салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Байршил

Үүнээс 16 нь Улаанбаатар хотод, 1 нь Эрдэнэт хотод үйл ажиллагаа явуулж байна.

5 аймаг

Инвескор Аллианс төсөл нь Монгол улсын 5 аймаг тус бүрт гишүүн ББСБ-тай.



Киргиз Улс дахь салбар

Киргиз Улсын Бишкек хотод 2 охин компани, 4 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Агуулга	1. Гол амжилтууд	2. Компанийн бүтэц	3. Зээлийн үйл ажиллагаа	4. Борлуулалтын суваг	5. Олон улсын зах зээл	6. Покет - Дижитал зээл
	7. Платинум Кредит карт	8. Нийгмийн хариуцлага	9. Компанийн засаглал	10. Санхүүгийн үр дүн	11. Зохистой харьцааны үзүүлэлтүүд	12. Хувьцааны ханш

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

“Инвескор ББСБ” ХК нь олон улсад зах зээлээ тэлэх стратегийн хүрээнд Киргиз улсад 2 охин компани (“Invescore CA” MFC, “Pocket KG” LLC) байгуулсан бөгөөд үйл ажиллагаа нь хурдацтай тэлж, өргөжиж байна.

“INVESCORE CA” MFC

Компани нь 33 ажилтан, 4 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. 2022 онд 18 тэрбум төгрөгийн зээл олголт хийсэн байна.

2022 оны үр дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:



17 тэрбум ₮

Зээлийн багц 17 тэрбум төгрөгт хүрч 150%-иар өссөн.

19 тэрбум ₮

Нийт хөрөнгө 19 тэрбум төгрөгт хүрч 139%-иар өссөн.

1.7%

Хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь 3.3%, чанаргүй зээлийн эзлэх хувь 1.7% байна.

28%

Нийт зээлийн тоо 1064-т хүрч 28%-иар өссөн.

“POCKET KG” LLC



Компани нь Монгол улсын зах зээлд тэргүүлж буй дижитал хэтэвч, цахим зээлийн Покет платформыг Киргиз улсын зах зээлд нийцүүлэн нэвтрүүлж байна.

Тус платформуор дамжуулан Киргиз улсын зах зээлд цахим зээлийн бүтээгдэхүүнийг санал болгосноор шинэ харилцагчдыг татаж зах зээлээ өргөжүүлэх онцгой ач холбогдолтой юм.

Агуулга	1. Гол амжилтууд	2. Компанийн бүтэц	3. Зээлийн үйл ажиллагаа	4. Борлуулалтын суваг	5. Олон улсын зах зээл	6. Покет - Дижитал зээл
	7. Платинум Кредит карт	8. Нийгмийн хариуцлага	9. Компанийн засаглал	10. Санхүүгийн үр дүн	11. Зохистой харьцааны үзүүлэлтүүд	12. Хувьцааны ханш

ПОКЕТ - ДИЖИТАЛ ЗЭЭЛ

Гол бүтээгдэхүүн, үйлчилгээ

Pocket Loan	Pocket Pay	Pocket Coupon	Pocket Zero
70.5 тэрбум төгрөгийн зээлийн багц	Цахим төлбөр тооцооны 590 мянга + бүртгэлтэй хэрэглэгч	210+ нэр төрлийн купон, 180+ хамтрагч байгууллага	1000+ Мерчант, 1200+ Брэнд, 1580+ Салбар

Анхны SHOWROOM үйлчилгээний салбар нээгдлээ



ISO/IEC 27001:2013 Олон улсын стандартыг амжилттай нэвтрүүллээ

CERTIFICATE

MSECB hereby certifies that the management system of

Invescore Wallet NBFI LLC

Sukhbaatar district, 2nd Khoroa, Seouf street 19A, Twin Tower I, 15th Floor, (Aanambador, 425), Mongolia

Has been assessed and found to be in accordance with the management system requirements in

ISO/IEC 27001:2013

Certification Scope:

Financial services including digital loan, buy now - pay later, and payment solutions in accordance with the Statement of Applicability (SoA), Ver.1.0 dated 2022-07-07

Certificate No. **CT797-ISM5636-12-22**
 Certified since **2022-12-01**
 Valid from **2022-12-01**
 Valid until **2025-10-31**

*Subject to annual surveillance audits

This certificate can be validated by email request at: info@mseccb.com
 www.mseccb.com

MSECB
 655 East 807 Street, Denver, CO
 1-800-368-7963 Canada
 +1-970-426-7322

Temporary Certificate - To be used until reception of the official hard copy certificate



Урт хугацаат зээлийн бүтээгдэхүүн

Pocket аппликейшнтэй урт хугацаанд хамт байсан, санхүүгийн сахилга баттай, үнэнч хэрэглэгчдэдээ зориулан “Урт хугацаат зээлийн бүтээгдэхүүн”-ийг нэвтрүүллээ.

ИНВЕСКОР ПЛАТИНУМ КАРТ



“Инвескор ББСБ” ХК нь өөрсдийн үнэнч харилцагч нартаа зориулан дэлхийн хаана ч ашиглах боломжтой олон улсын эрхтэй төгрөгийн VISA КРЕДИТ КАРТ-г хэрэглээнд нэвтрүүлж эхэлсэн билээ.

2019 онд анхны кредит картаа Худалдаа Хөгжлийн Банктай хамтран гаргаж байсан бол энэ удаа Голомт банктай хамтран Инвескор Платинум кредит картыг үнэнч харилцагч нартаа санал болгон ажиллаж байна.

Инвескор Платинум картын давуу тал

- ✓ Минималист хэв маягийг агуулсан гоёмсог загвартай
- ✓ Дэлхийн аль ч улсад төлбөр тооцоо, гүйлгээ хийх боломжтой
- ✓ Зайнаас уншигч NFC технологийг агуулсан
- ✓ Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг EMV чип технологиор хамгаалсан
- ✓ Харилцагчийн овог, нэр зэрэг хувийн мэдээллийг картын нүүрэн талд байрлуулдаггүй



Буцаан олголттой

10-15% -ийн буцаан олголт



Хамгийн бага хүү

2-2.8% сарын хүү



Лоялти хөтөлбөрүүд

VISA

Агуулга	1. Гол амжилтууд	2. Компанийн бүтэц	3. Зээлийн үйл ажиллагаа	4. Борлуулалтын суваг	5. Олон улсын зах зээл	6. Покет - Дижитал зээл
	7. Платинум Кредит карт	8. Нийгмийн хариуцлага	9. Компанийн засаглал	10. Санхүүгийн үр дүн	11. Зохистой харьцааны үзүүлэлтүүд	12. Хувьцааны ханш

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

FIFA WORLD CUP QATAR 2022 - Шууд дамжуулалтын ерөнхий ивээн тэтгэгч

Инвескор санхүүгийн байгууллага нь Катар улсад зохион байгуулагдсан Хөлбөмбөгийн ДАШТ-ийн шууд дамжуулалтын Ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллалаа.



Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр



Ковид-19 цар тахлын дараа Монгол улсын эдийн засгийг сэргээхэд дэмжлэг үзүүлэх, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг “Инвескор ББСБ” ХК нь “Рио Тинто Монгол” ХХК-тай хамтран хэрэгжүүлж байна.

Нийт харилцагчийн эзлэх хувь



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

НҮБ-ын залуу төлөөлөгч - Байгаль орчны манлайлал хөтөлбөр



"Инвескор ББСБ" ХК нь Монгол Улсад анх удаа хэрэгжиж байгаа "НҮБ-ын залуу төлөөлөгч - Байгаль орчны манлайлал" хөтөлбөрийг дэмжин ажиллалаа. 🌱

Тус хөтөлбөрийн хүрээнд байгаль орчинд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд өөрийн хувь нэмрээ оруулах хүсэлтэй 18-30 насны 30 залууг шалгаруулсан. Сонгогдсон оролцогчид 2 сарын турш байгаль орчны тухай мэдлэгээ тэлэн сургалтанд хамрагдсан бөгөөд байгаль орчинд тулгарч буй асуудлуудыг шийдэх төсөл санаачлан хэрэгжүүлж эхэлсэн болно.

Тэрбум мод аян

Инвескор ББСБ ХК "ТЭРБУМ МОД" аяныг дэмжиж Санхүүгийн Зохицуулах Хороотой хамтран Өвөрхангай аймгийн Хархорин суманд мод тарьж байгаль орчиндоо эерэг хувь нэмэр орууллаа.



Тэнцвэр аян

Покетын хамт олон экологийн тэнцвэрийг хадгалах хүрээнд минж үржүүлэх нутагшуулах төвийн үйл ажиллагааг дэмжих, мод тарих, модны ургалтыг дэмжих, цэвэр усны нөөцийг хэмнэх, залуусын хандлагыг эерэг байлгах, санхүүгийн хариуцлагатай байх зэрэг чиглэлүүдээр "ТЭНЦВЭР АЯН" -ыг хэрэгжүүллээ.

ZeroExpo зохион байгууллаа

Уг экспод +30,000 хүн оролцсон ба Expo-н хүрээнд тэнцвэр аянаа сурталчлан, нийгэмд байгаль экологи, хандлага зэрэг олон сэдвээр эерэг нөлөөллийг түгээсэн. Үндэсний үйлдвэрлэгч, эко мерчантуудыг онцлон дэмжлэг үзүүлсэн.



Шилдэг нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч

Pocket аппликейшний хамт олон Шилдэг нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч байгууллагаар шалгаран МББСБ холбооны нэрэмжит "Алтан Од" шагналын эзэн болов.

Агуулга	1. Гол амжилтууд	2. Компанийн бүтэц	3. Зээлийн үйл ажиллагаа	4. Борлуулалтын суваг	5. Олон улсын зах зээл	6. Покет - Дижитал зээл
	7. Платинум Кредит карт	8. Нийгмийн хариуцлага	9. Компанийн засаглал	10. Санхүүгийн үр дүн	11. Зохистой харьцааны үзүүлэлтүүд	12. Хувьцааны ханш

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүн



Б.Анхболд

ТУЗ-ийн дарга
“Эс Ай Би Жэй Капитал” ХХК
Гүйцэтгэх захирал



Д.Баясгалан

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал
“Инвескор ББСБ” ХК
Гүйцэтгэх захирал



Ч.Хашчулуун

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Монгол Улсын Их Сургуулийн
Эдийн Засгийн тэнхимийн
Профессор



Р.Пүрэв

ТУЗ-ийн гишүүн
“Эс Ай Би Жэй Капитал” ХХК
Дэд захирал



Д.Энхбат

ТУЗ-ийн хараат бус гишүүн
“Хархорум Дижитал” ХХК
Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал



Н.Хирохито

ТУЗ-ийн гишүүн
“Инвескор Жапан” ХХК
Гүйцэтгэх захирал



Ч.Өнөржаргал

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Санхүү Эдийн Засгийн Их Сургууль
Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн
ахлах багш



Г.Уянгахишиг

ТУЗ-ийн гишүүн
“Инвескор Капитал УЦК” ХХК
ТУЗ-ийн дарга



Т.Тэлмэн

ТУЗ-ийн гишүүн
“Амар Даатгал” ХХК
Бизнес хөгжлийн газрын захирал

Аудитын хороо
 Эрсдэлийн удирдлагын хороо
 Цалин урамшууллын хороо
 Нэр дэвшүүлэх хороо
 Тухайн хорооны дарга

ТУЗ-ийн дэргэд түүний гишүүдээс бүрдсэн Аудитын, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын, Эрсдэлийн удирдлагын хороод байнгын үйл ажиллагаа явуулдаг. Хороод тус бүр 3 гишүүний бүрэлдэхүүнтэй. 2022 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын ирц дунджаар 88% байна. Сонирхлын зөрчилтэй хэлцлийн тоо 10 байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороод		Аудитын хороо	Дарга: Ч.Хашчулуун	Гишүүд: Ч.Өнөржаргал, Р.Пүрэв
		Нэр дэвшүүлэх хороо	Дарга: Ч.Хашчулуун	Гишүүд: Д.Энхбат, Х.Намики
		Цалин урамшууллын хороо	Дарга: Д.Энхбат	Гишүүд: Т.Тэлмэн, Ч.Өнөржаргал
		Эрсдэлийн удирдлагын хороо	Дарга: Ч.Өнөржаргал	Гишүүд: Б.Анхболд, Ч.Хашчулуун

Дотоод аудитын тогтолцоо

Байгууллага нь хамгаалалтын гурван бүс бүхий эрсдлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлдэг бөгөөд Дотоод аудитын газар нь хамгаалалтын гуравдугаар бүсийн чиг үүрэг болох хараат бус баталгаажуулалтаар хангаж ажилладаг. Компанийн бүтцийн хувьд дотоод аудитын газар нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны шууд удирдлага доор үйл ажиллагаагаа явуулдаг.

Дотоод аудит нь оновчтой, эрсдэлд суурилсан хандлагаар байгууллагын Эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоо, засаглал болон дотоод хяналтын үйл явцыг үнэлэх бөгөөд Компанийн үзүүлж байгаа ажил, үйлчилгээ нь холбогдох хууль, журамд нийцэж байгаа эсэхэд хяналт хийх, эрсдэлийг тодорхойлох, эрсдэлээс урьдчилан сэргийлж зөвлөмж гаргах, компанийн үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэн үнэ цэнэ нэмэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Агуулга	1. Гол амжилтууд	2. Компанийн бүтэц	3. Зээлийн үйл ажиллагаа	4. Борлуулалтын суваг	5. Олон улсын зах зээл	6. Покет - Дижитал зээл
	7. Платинум Кредит карт	8. Нийгмийн хариуцлага	9. Компанийн засаглал	10. Санхүүгийн үр дүн	11. Зохистой харьцааны үзүүлэлтүүд	12. Хувьцааны ханш

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Байгаль орчин, нийгмийн бодлого, эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Инвекор ББСБ нь 2022 онд байгууллагын байгаль орчин, нийгмийн хүрээнд баримтлах зарчмууд, ногоон бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжүүлэлт, дотоод үйл ажиллагааны хүрээлэн буй орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг бууруулах зэрэг асуудлуудыг тусган “Байгаль орчин, нийгмийн бодлого”-г шинэчлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлуулсан.

Байгаль орчин, нийгэмд өндөр хор хөнөөлтэй үйл ажиллагааг Инвекор ББСБ нь санхүүжүүлэхээс татгалздаг бөгөөд санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалтыг олон улсын шаардлагын дагуу тухай бүр шинэчлэн дагаж мөрддөг.

Тогтвортой хөгжлийн чиглэлээрх хамтын ажиллагаа

Тогтвортой Санхүүгийн Холбоо (ТоС)



Инвекор ББСБ нь ТоС Холбооны үндсэн гишүүнээр нэгдэн орж, үйл ажиллагаандаа ТоС -ын 8 зарчмыг дэмжиж хэрэгжүүлэн ажиллахыг эрмэлзэж байна. Түүнчлэн, ТоС Холбооноос хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд, сургалтуудад идэвхтэй оролцон тогтвортой санхүүжилтийн чадавхыг ахиулан ажилласан байна.

НҮБ-ын Даян дэлхийн гэрээнд нэгдсэн анхны ББСБ боллоо



Инвекор ББСБ нь тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд UN Global Compact буюу НҮБ-ын “Даян дэлхийн гэрээ”-нд үүрэг амлалт хүлээн нэгдэн орлоо. Энэхүү гэрээнд нэгдсэнээр Инвекор ББСБ нь хүний эрхийг дээдлэх, хөдөлмөр эрхлэлтийн зохистой орчныг бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, авлигал, хээл хахуулийн эсрэг тууштай үйл ажиллагаа явуулах гэсэн 4 үндсэн чиглэлээр 10 зарчмыг бизнесийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах юм.

Тогтвортой ажиллах хүч

Инвекор ББСБ-ын Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан “Байгаль орчин, нийгмийн бодлого”-д тогтвортой ажиллах хүчийг тогтвортой бизнесийн гол хүчин зүйл гэж авч үзэх ба ажиллах хүчний сонгон шалгаруулалт, сургалт хөгжил, хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагаандаа дараах зарчмуудыг баримтлан ажилладаг.

Үл ялгаварлан гадуурхах

Тогтвортой өсөлт хөгжил, сургалтын тогтолцоо

Эрүүл аюулгүй ажиллах нөхцөл

Ажлын байрны ёс зүй

Агуулга	1. Гол амжилтууд	2. Компанийн бүтэц	3. Зээлийн үйл ажиллагаа	4. Борлуулалтын суваг	5. Олон улсын зах зээл	6. Покет - Дижитал зээл
	7. Платинум Кредит карт	8. Нийгмийн хариуцлага	9. Компанийн засаглал	10. Санхүүгийн үр дүн	11. Зохистой харьцааны үзүүлэлтүүд	12. Хувьцааны ханш

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Харилцагчийн үйлчилгээ

Инвескор ББСБ нь харилцагчидтайгаа харилцах тасралтгүй холбоог эрхэмлэхээс гадна "Харилцагч төвтэй" бодлогыг хэрэгжүүлэхээр "Харилцагчийн Үйлчилгээний Төв"-ийг бий болгон ажиллаж байна.

Харилцагчийн үйлчилгээний төв нь 2022 оны IV улирлын турш нийт 11,227 удаагийн харилцагчийн хандалт, хүсэлт, асуудлыг дуулагын төв, сошиал суваг болон салбараар дамжуулан хүлээн авч, харилцагчдад тулгарсан асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна.

- ✓ 2022 оны IV улиралд:
- ✓ 4319 Нийт дуудлага
- ✓ 5658 Сошиал сувгаар үйлчилсэн
- ✓ 1250 Салбараар үйлчилсэн

Харилцагчийн гомдол шийдвэрлэлт

Харилцагчийн үйлчилгээний төв нь 2022 оны IV улиралд лавлах дугаар, сошиал сувгууд (пэйж хуудас, веб сайт, и-мэйл) болон салбар, төв оффист биечлэн ирсэн харилцагчтай уулзалт хийж, нийт бүртгэгдсэн гомдлыг 100% шуурхай шийдвэрлэсэн байна.



Харилцагчаас ирүүлсэн санал, хүсэлт шийдвэрлэлтийн дундаж хугацааг өмнөх улирлын дунджаас 25 хувиар бууруулж ажиллалаа.

Харилцагчийн сэтгэл ханамж

Инвескор ББСБ ХК нь харилцагчдынхаа сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилгоор улирал бүр дотоод судалгаа, жил бүр мэргэжлийн судалгааны байгууллагаар сэтгэл ханамжийн судалгаа хийлгэж байна. Бид харилцагчдынхаа сэтгэл ханамжийг дээшлүүлэх, хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж чанараа сайжруулах зорилгоор бусад газар, нэгжүүдтэй хамтран сайжруулалтын ажлыг тодорхойлон, тухай бүр хэрэгжүүлэн ажиллаж байна.

Ханган нийлүүлэгчтэй хамтын ажиллагаа

Компанийн үйл ажиллагаа болон үйлчилгээний процессыг тасралтгүй ажиллуулахад шаардлагатай бараа материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, тавилга эд хогшил болон бусад хангамжийн материалын худалдан авалтын үйл ажиллагааг хэвийн үр дүнтэй хангахын зэрэгцээ зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэхийг зорин ажилладаг. Бараа ажил үйлчилгээг эрсдэлийн түвшин, мөнгөн дүнгийн хэмжээ, зах зээлийн өрсөлдөөний харьцуулсан судалгаанд үндэслэн худалдан авалтын тодорхой аргаар бэлтгэн нийлүүлдэг бөгөөд тухайн аргад нийцсэн нөхцлөөр бэлтгэн нийлүүлэгчийг сонгодог.

Агуулга	1. Гол амжилтууд	2. Компанийн бүтэц	3. Зээлийн үйл ажиллагаа	4. Борлуулалтын суваг	5. Олон улсын зах зээл	6. Покет - Дижитал зээл
	7. Платинум Кредит карт	8. Нийгмийн хариуцлага	9. Компанийн засаглал	10. Санхүүгийн үр дүн	11. Зохистой харьцааны үзүүлэлтүүд	12. Хувьцааны ханш

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮН (аудитлагдсан)

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ХУРААНГУЙ /мянган ₮/


	2020	2021	2022
	Аудитлагдсан	Аудитлагдсан	Аудитлагдсан
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	26,588,673	24,638,751	50,043,133
Хөрөнгө оруулалт	591,122	-	6,922,715
Харилцагчдад олгосон зээл-цэвэр	96,409,802	175,508,816	282,331,254
Нийт зээл	95,290,686	173,192,374	282,556,026
Эрсдэлийн сан	2,742,355	3,146,865	8,179,303
Хүүний авлага	3,861,471	5,463,307	7,954,531
Авлага	1,534,115	3,274,706	2,030,566
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	821,892	783,568	561,450
Бусад актив	492,217	2,163,643	8,934,238
Үндсэн ба биет бус хөрөнгө	9,606,490	5,852,811	7,687,545
Нийт хөрөнгийн дүн	136,044,313	212,222,295	358,510,901
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	42,209,511	56,477,725	85,440,869
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	14,100,200	34,396,459	69,458,371
Бонд	7,878,886	27,620,907	44,170,514
Бусад өглөг	19,055,330	18,191,687	36,187,806
Нийт өр төлбөрийн дүн	83,243,727	136,686,778	235,257,560
Хувьцаат капитал	16,282,237	16,282,237	17,193,952
Нэмж төлөгдсөн капитал	15,377,738	15,377,738	29,820,733
Хоёрдогч өглөг	(51,671)	5,000,000	5,000,000
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	21,192,282	38,903,472	70,616,038
Нийт өөрийн хөрөнгө	52,800,586	75,535,517	123,253,341
Нийт пассив ба өөрийн хөрөнгө	136,044,313	212,222,295	358,510,901

ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ /мянган ₮/

	2020	2021	2022
Хүү болон түүнтэй адилтгах орлого	29,147,505	41,122,071	81,051,603
Хүү болон түүнтэй адилтгах зардал	6,755,193	12,945,026	25,604,130
Бусад хүүгийн зардал	2,593,650	5,336,908	14,286,167
Итгэлцлийн үйл ажилллагааны зардал	4,161,543	7,608,118	11,317,963
Хүүгийн цэвэр орлого	22,392,312	28,177,045	55,447,473
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	450,277	8,886,652	13,244,471
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого, зардал	86,738	(157,173)	(35,824)
Нийт хүүгийн бус цэвэр орлого	537,015	8,729,479	13,208,647
Нийт үйл ажиллагааны орлого	22,929,327	36,906,524	68,656,120
Ажиллагсадтай холбогдолтой зардал	3,170,017	5,525,727	8,858,395
Үйл ажиллагааны бусад зардал	4,116,052	6,668,458	11,434,683
Нийт үйл ажиллагааны зардал	7,286,069	12,194,185	20,293,078
Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал	1,297,947	743,455	5,100,701
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	(440,215)	(258,566)	(299,234)
Татварын өмнөх ашиг	13,905,096	23,710,318	42,963,107
Орлогын албан татвар	2,285,987	4,500,028	9,337,543
Тайлант үеийн цэвэр ашиг	11,619,109	19,210,290	33,625,564


САНХҮҮГИЙН ҮР ДҮН (аудитлагдсан)

Нийт хөрөнгө (сая төгрөг)




Нийт хөрөнгө өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 69 хувиар өсч, 359 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Өөрийн хөрөнгө (сая төгрөг)




Өөрийн хөрөнгө өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 63 хувиар өсч 123 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Хүү, шимтгэлийн орлого (сая төгрөг)



Хүү, шимтгэлийн орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 88 хувиар өсч 94 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Цэвэр ашиг (сая төгрөг)




Цэвэр ашиг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 75 хувиар өсч 34 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Агуулга	1. Гол амжилтууд	2. Компанийн бүтэц	3. Зээлийн үйл ажиллагаа	4. Борлуулалтын суваг	5. Олон улсын зах зээл	6. Покет - Дижитал зээл
	7. Платинум Кредит карт	8. Нийгмийн хариуцлага	9. Компанийн засаглал	10. Санхүүгийн үр дүн	11. Зохистой харьцааны үзүүлэлтүүд	12. Хувьцааны ханш

ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД (тусдаа)

Шалгуур үзүүлэлт	Байх ёстой	2021	2022
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	30.7%	32.4%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	33.1%	34.0%
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-иас доошгүй	31.7%	31.0%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	16.2%	25.3%
Нэг зээлдэгч, түүний холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө	30%-иас хэтрэхгүй	11.7%	9.4%
ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	70%-иас хэтрэхгүй	0.0%	0.0%
Нийт холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө	25%-иас хэтрэхгүй	0.4%	4.3%
Нэг холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө	10%-иас хэтрэхгүй	0.0%	4.0%
Үнэт цаасны эзэмшил / өөрийн хөрөнгө	50%-иас хэтрэхгүй	8.5%	11.8%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	+/-40%-иас хэтрэхгүй	18.0%	2.9%
Итгэлцлийн өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	74.7%	76.6%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	38.5%	39.9%
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	15%-иас хэтрэхгүй	0.9%	0.6%

ХУВЬЦААНЫ ХАНШ



Үнэт цаасны код

INV

Зах зээлийн үнэлгээ

379 тэрбум төгрөг

Гаргасан хувьцааны тоо ширхэг

75,744,281 ширхэг

Хаалтын ханш /2022.12.31/

5005 төгрөг

IPO-с хойших өсөлт

203% /3x/

Хувьцааны ханш:

5005₮

2022 оны өсөлт:

24%



IPO-с хойш:

203% /3x/



“Инвекор ББСБ” ХК-ийн хувьцаа нь МХБ-ийн ТОП-20 индекс болон хувьцааны бүртгэлийн I ангилалд багтдаг.